

**БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

ХООРОНДЫН

САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газрыг төлөөлж Холбооны Сангийн сайд нар, цаашид "Гэрээлэгч талууд" гэх:

- Хоёр орон хоорондын найрсаг харилцааг цаашид үргэлжүүлэн хөхиүлэн дэмжихийг эрмэлзэн,
- Хамтын ажиллагааг өргөжүүлэн, гүнзгийрүүлэхийг мөн эрмэлзэн

дараах зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

1 дүгээр зүйл

1.1 Хэлэлцэн тохиролцогч талууд нь өөрийн орны хүчин төгөлдөр хууль, дүрэм, журам, баримталж буй бодлого болон олон улсад хүлээсэн үүргийн хүрээнд санхүүгийн хамтын ажиллагаагаа хөхиүлэн дэмжиж өргөжүүлэхээр чармайн ажиллана.

2 дугаар зүйл

2.1 Санхүүгийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж, өргөжүүлэх зорилгоор Австрийн Холбооны Сангийн сайд нийт 40,000,000 евро (Дөчин сая евро)-гийн үнийн дүн бүхий зээлийг хөнгөлөлттэй нөхцлөөр олгон, энэхүү хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд заасан төслүүдийг Экспортын санхүүжилтийн системийн дагуу арилжааны банкуудаар дамжуулан дахин санхүүжүүлэх зарчмаар Вена хот дахь Австрийн Контролбанк ХК (ОеКВ)-наас санхүүжүүлэхийг зөвшөөрөв.

3 дугаар зүйл

3.1 Австрийн хөнгөлөлттэй зээл нь хөнгөлөлтийн түвшингийн хамгийн доод шаардлагыг хангахуйц холимог ба урьдчилан холигдсон зээлийн хувилбарт бүхий нөхцөлт санхүүжилтийн хэлбэрээр олгогдоно.

3.2 Нөхцөлт зээлийн нөхцөл нь Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа байгууллага (ОУЭЗХАБ)-ын "Албан ёсоор дэмжигдсэн экспортын зээлийн тохиролцоо", Олон улсын валютын сан (ОУВС)-гийн Өрийн хязгаарын бодлого зэрэг олон улсын баримт бичгийн аль хамааралтайг үндэслэн тогтоогдоно. Үүнтэй нийцүүлэн нөхцөлт зээлийн хөнгөлөлтийн түвшин нь хамгийн багадаа 35% байна. Зээлийн нөхцлийг 2011 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар Хавсралт 1-д тусгав.

3.3 Хэлэлцэн тохиролцогч талууд зээлийн хугацаа, нөхцөл нь ОУЭЗХАБ-ны тохиролцооны дагуу жил бүр дахин тогтоодог хөнгөлөлтийн түвшин, ОУВС-гийн хөнгөлөлтийн түвшинтэй холбогдон гарч болзошгүй өөрчлөлт, мөн ОУЭЗХАБ-ын улс, орнуудын эрсдэлийн ангилал зэргээс хамаарч өөрчлөгдөх болохыг тэмдэглэв.

3.4 Мөн түүнчлэн баталгааны хураамжийг хэсэгчлэн нөхөх зорилгоор албан ёсны эх үүсвэрээс олгогдож буй буцалтгүй тусламжийн хөрөнгийг тухай бүр олгох боломжтой.

4 дүгээр зүйл

4.1 Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн төслийн жагсаалтыг гаргах ба тэрхүү жагсаалтыг Хэлэлцэн тохиролцогч талууд тухай бүр шинэчлэн, харилцан солилцоно.

4.2 Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлэгдэхээр төслүүдийн сонгогдох боломжийг "Хэлсинки"-ийн нөхцөлт тусламжийн журам болон улсын төсвийн хуваарилалтын шалгуур үзүүлэлтийн аль тохиромжтойг харгалзан үнэлэн, тогтооно.

4.3 "Хэлсинки"-гийн нөхцөлт тусламжийн журмын санхүүгийн шаардлага хангаагүй төслүүдийн туршлагаас үндэслэн дараах төсөл/салбаруудыг хөнгөлөлттэй санхүүжилт олгохоор харгалзан үзнэ. Үүнд:

- Дэд бүтэц;
- Орон нутгийн ус, эрүүл ахуй;
- Хог хаягдал, бохир ус;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдал, төмөр зам;
- Боловсрол, техник, мэргэжлийн сургалт;
- Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал (хот, орон нутгийн гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа, гамшгийн анхааруулга гэх мэт).

5 дугаар зүйл

5.1 Төслийн худалдан авах ажиллагааг Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу явуулна.

6 дугаар зүйл

6.1 Австрийн Контрол банк (OeKB)-наас дахин санхүүжигдэх зээлийн хэлэлцээрүүдийн нөхцлийг зээлдүүлэгч болох арилжааны банкууд болон зээлдэгч болох Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам хооронд шууд хэлэлцээ хийх замаар тохирч, байгуулна.

7 дугаар зүйл

7.1 Энэхүү Хэлэлцээрт хамрагдан санхүүжүүлэгдэх төслүүдийг Монгол Улсын Сангийн яам, Бүгд Найрамдах Австри Улсын Холбооны Сангийн яам хооронд захидал солилцох замаар тохиролцоно.

Энэ үйл ажиллагаа нь энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болсоноос 24 сарын хугацаанд дэс дараалласан байдлаар явагдана. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө хэлэлцээ хийгдэж байсан төслүүдийг мөн энэхүү Хэлэлцээрт хамруулж болно.

8 дугаар зүйл

8.1 Энэхүү хэлэлцээрийн хүрээнд олгож буй нөхцөлт тусламжийн зээлийн хөрөнгийг Австри Улсын бараа, ажил үйлчилгээг худалдан авахад ашиглах бөгөөд хөрөнгийн 50 хүртэлх хувийг Австри Улсын бус үүсэлтэй худалдан авалтад зориулж болно.

9 дүгээр зүйл

9.1 Энэхүү Хэлэлцээрээр бий болж буй бүх төлбөрийг эргэж буцалтгүйгээр, үл маргах замаар гүйцэлдүүлэхийг Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам үүгээр баталгаажуулан, энэхүү Хэлэлцээрээр баталгаажуулсан төлбөрөөс чөлөөлөгдөх аливаа эрхээсээ эргэж буцалтгүйгээр түдгэлзэв.

10 дугаар зүйл

10.1 Австрийн экспортын санхүүжилтийн системийн дэмжлэгтэйгээр олгогдсон албан ёсны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ногдуулах Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөнө.

10.2 Австрийн экспортын санхүүгийн системийн дэмжлэгтэйгээр олгогдсон албан ёсны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Зээлдэгчийн хийсэн төлбөрт ногдох татварын

хөнгөлөлт, чөлөөлөлтийг 2003 оны 7 дугаар сарын 3-ны өдөр байгуулсан “Монгол Улс, Бүгд Найрамдах Австри Улс хоорондын Орлого болон хөрөнгийн албан татварын тухай Хэлэлцээр”-ээр зохицуулна.

11 дүгээр зүйл

11.1 Хэлэлцэн тохиролцогч талууд энэхүү Хэлэлцээрийн явцыг үнэлж, шинэчлэлтийн асуудлаар хэлэлцэж, гарч болзошгүй бусад асуудлаар жил бүр эсхүл шаардлагатай тохиолдолд тухай бүр харилцан тохиролцоно.

12 дугаар зүйл

12.1 Хөнгөлөлттэй зээлийн ашиглалтыг үнэлэх зорилгоор энэхүү Хэлэлцээрийн хүрээнд болон холбогдох төслүүдийн тогтвортой байдлыг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газар төслүүдийн хэрэгжилтийн явцыг үнэлэх, хянах, аудит хийхэд шаардлагатай бүхий л баримт бичгээр хангахад дэмжлэг үзүүлнэ.

13 дугаар зүйл

13.1 Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх ба/эсхүл тайлбарлахад Хэлэлцэн тохиролцогч талуудын хооронд үүссэн аливаа маргааныг найрсагаар дипломат шугамаар шийдвэрлэнэ.

14 дүгээр зүйл


14.1 Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч талууд дотоодынхоо хууль, тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа харилцан мэдэгдсэн сарын дараагийн сарын эхний өдрөөс хүчин төгөлдөр болно.

14.2 Энэхүү Хэлэлцээр нь 2 (хоёр) жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

14.3 Энэхүү Хэлэлцээрийг харилцан тохиролцсоноор дахин 2 (хоёр) жилээр сунгагдана. Хэлэлцээрийг Хэлэлцэн тохиролцогч талын аль нэг нь хэдийд ч цуцлах тухай мэдэгдэл гаргах замаар цуцалж болох ба иймхүү цуцлах тухай мэдэгдэл гаргасан өдрөөс хойш 6 сарын дараа Хэлэлцээр хүчингүй болно. Хэлэлцээрийг цуцлах нь энэхүү Хэлэлцээрийн 4, 8 дугаар зүйлийн дагуу хэрэгжиж байгаа үйл ажиллагаатай холбоотой Хэлэлцэн тохиролцогч талуудын үүрэгт нөлөөлөхгүй.


Энэхүү Хэлэлцээрийг 2011 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Улаанбаатар хотноо монгол , герман, англи хэлээр 2 эх хувь байгуулсан бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Монгол, герман хэлээрх эх бичвэрийг тайлбарлахад зөрүү гарсан тохиолдолд англи хэлээрх эхийг баримтална.

БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



ХОЛБООНЫ САНГИЙН САЙД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



САНГИЙН САЙД

(Австри Улсаас Монгол Улсад суугаа
Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд
Мартин Сайдик)

Хавсралт 1

3.2. дугаар зүйлийн хөнгөлөлттэй зээлийн нөхцөлүүд

2011 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс 2012 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр хүртэл хүчинтэй

1) Урьдчилан холигдсон зээл

100%-ийн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөгдөх төсөл нь дараах нөхцөлтэй байна. Үүнд:

| | Эргэн төлөгдөх хугацаа | Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх жил | Хүүгийн хэмжээ | Барьцаа төлөлт (Заасан нөхцөл) |
|-----------|------------------------|----------------------------------|----------------|--------------------------------|
| Сонголт 1 | 18 жил | 5 жил | Жилийн 0.40% | 13.77%=1.715 жилийн хэмжээ |
| Сонголт 2 | 15 жил | 5 жил | 0% | 12.15 %=1663 жилийн хэмжээ |

2) Холимог зээл: Дараах төрөлтэй:

- a) Эргэн төлөгдсөн төслийн өртөг (хамгийн ихдээ 15,000,000.00 Евро)-ийн 15 хувьтай тэнцэх буцаан олгогдохгүй буцалтгүй тусламж
- b) Эргэн төлөгдсөн төслийн өртгийн 85%-тай тэнцэх хөнгөлөлттэй зээл дараах нөхцөлтэй байна. Үүнд:

| | Эргэн төлөгдөх хугацаа | Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх жил | Хүүгийн хэмжээ | Барьцаа төлөлт (Заасан нөхцөл) |
|-----------|------------------------|----------------------------------|----------------|--------------------------------|
| Сонголт 1 | 15 жил | 3 жил | Жилийн 1.15% | 13.02%=1.980 жилийн хэмжээ |
| Сонголт 2 | 11 жил | 2.5 жил | 0% | 10.02 %=1880 жилийн хэмжээ |